



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,  
БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ХООРОНДЫН  
ТЭТГЭВРИЙН АСУУДЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн Газар (цаашид "Талууд" гэх) тэтгэвэр тогтоох, олгох асуудлаар хамтын ажиллагааг хөгжүүлэх хүсэл эрмэлзлийг удирдлага болгон доор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов:

Нэгдүгээр зүйл  
Үндсэн ойлголтууд

1. Энэхүү Хэлэлцээрийн зорилгоор дараах үндсэн ойлголтуудыг хэрэглэнэ:

"оршин суугаа улс" гэж тэтгэвэр тогтоолгох өргөдөл гаргагчийн нутаг дэвсгэрт нь байнга оршин сууж байгаа улсыг;

"хууль тогтоомж" гэж тэтгэвэр тогтоох, олгох асуудлыг зохицуулсан Талуудын улсын хууль, эрх зүйн бусад баримт бичгүүдийг;

"өргөдөл гаргагч" гэж тэтгэвэр тогтоолгоо хандсан этгээдийг, эсхүл түүний нэрийн өмнөөс эрх ашгийг нь төлөөлөх итгэмжлэгдсэн этгээдийг;

"эрх бүхий байгууллага" гэж Талуудын энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлж буй байгууллагыг;

"оршин суугаа газар" гэж Талуудын улсын хууль тогтоомжийн дагуу байнга оршин суугаа газар гэж тодорхойлсон буюу хүлээн зөвшөөрсөн өргөдөл гаргагчийн байнга оршин суугаа газрыг;

"тэтгэвэр" гэж энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар эүйлийн 2-т заасан тэтгэврийн төлбөрийг;

"хүний хувийн мэдээлэл" гэж цахим, цаасан хэлбэрээр болон (эсхүл) өөр материаллаг тээгч дээр хадгалагдсан өргөдөл гаргагч (тэтгэвэр авагч)-д хамаарах өгөгдлийг;

“тэтгэвэр авагч” гэж энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 2-т заасан тэтгэвэр тогтоолгосон этгээдийг;

“ажилласан (даатгуулсан) хугацаа” гэж ажилласан ба (эсхүл) тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа болон Талуудын улсын хууль тогтоомжид заасан бусад хугацааг;

“бүрэн эрхт байгууллага” гэж:

Монгол Улсын тухайд: Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг;

Бүгд Найрамдах Казахстан Улсын тухайд: Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын яамыг.

Аль нэг талын бүрэн эрхт байгууллагыг өөрчлөн зохион байгуулсан, эсхүл албан ёсны нэр нь өөрчлөгдсөн тохиолдолд тухайн Тал нь нөгөө Талдаа дипломат шугамаар нэн даруй энэ тухай мэдэгдэх ба холбогдох эрх мэдлийг шилжүүлэх арга хэмжээ авна.

2. Энэхүү Хэлэлцээрт хэрэглэгдэж байгаа бусад ойлголтыг Талуудын улсын хууль тогтоомжид тодорхойлсон утгаар хэрэглэнэ.

### Хоёрдугаар зүйл Хамаарах этгээд болон хамрах хүрээ

1. Энэхүү Хэлэлцээр нь нэг Талын улсын нутаг дэвсгэрт байнга оршин сууж байгаа бөгөөд нөгөө Талын улсын нутаг дэвсгэрт ажилласан (даатгуулсан) хугацаатай Талуудын улсын иргэдэд хамаарна.

2. Энэхүү Хэлэлцээр дараах төрлийн тэтгэвэрт хамаарна:

2.1. Монгол Улсын тухайд тэтгэврийн даатгалын сангаас олгох газрын доор, хөдөлмөрийн халуун, хортой, хүнд нөхцөлөөр эрт тогтоохоос бусад өндөр насны тэтгэвэр (цаашид “өндөр насны тэтгэвэр” гэх).

2.2. Бүгд Найрамдах Казахстан Улсын тухайд:

2.2.1. өндөр насны тэтгэврийн төлбөр;

2.2.2. тэтгэврийн албан журмын шимтгэл, мэргэжлийн тэтгэврийн албан журмын шимтгэлээр бүрдүүлэх тэтгэврийн хуримтлалаас тэтгэврийн насанд хүрэхэд олгох тэтгэврийн төлбөрүүд (цаашид “хуримтлалын тэтгэвэр” гэх).

3. Энэхүү зүйлийн 2-т заасан тэтгэврийг тогтоох ба олгох асуудлыг зохицуулж байгаа Талуудын улсын хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлт нь энэхүү

..... дугаар ..... 20-д

МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

ХУУЛБАР ҮНЭН

Хуубаш олгосон ажилти: ... онын үсэг  
25.09.2014  
2014 оны 14 сарын ...-ний өдөр

Хэлэлцээрийн заалтуудтай зөрчилдөөгүй бол энэхүү Хэлэлцээрт нэгэн адил хамаарна.

4. Энэхүү Хэлэлцээр дараах тэтгэвэрт хамаарахгүй:

Монгол Улсын тухайд -цэргийн алба хаасны тэтгэвэр;

Бүгд Найрамдах Казахстан Улсын тухайд -алба хаасан хугацааны тэтгэврийн төлбөр.

5. Энэхүү Хэлэлцээр нь 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Дипломат харилцааны тухай Венийн конвенц болон 1963 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Консулын харилцааны тухай Венийн конвенцийн холбогдох заалтад нөлөөлөхгүй.

**Гуравдугаар зүйл**  
**Тэтгэвэр тогтоох болон олгох**

1. Талуудын улсын иргэдийн тэтгэврийг оршин сууж буй улсын хууль тогтоомжийн дагуу тогтоох ба олгоно.
2. Монгол Улсын өндөр насны тэтгэврийг Монгол Улсын нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан журам ба нөхцөлийн дагуу тэтгэврийн даатгалын сангаас олгоно.
3. Бүгд Найрамдах Казахстан Улсын өндөр насны тэтгэврийн төлбөрийг Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжид заасан журам болон нөхцөлийн дагуу улсын төсвийн хөрөнгөнөөс олгоно.
4. Бүгд Найрамдах Казахстан Улсын хуримтлалын тэтгэврийг Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжид заасан журам болон нөхцөлийн дагуу тэтгэврийн хуримтлалын нэгдсэн сангаас олгоно.
5. Тэтгэвэр шилжүүлэхтэй холбогдсон нийт зардлыг тэтгэвэр тогтоож буй Тал хариуцна.
6. Монгол Улсад өндөр насны тэтгэвэр тогтоолгох, Бүгд Найрамдах Казахстан Улсад өндөр насны тэтгэврийн төлбөр тогтоолгох өргөдлийг оршин суугаа улсын хууль тогтоомжид заасан шаардлагатай баримт бичгийг хавсарган оршин суугаа улсын эрх бүхий байгууллагад гаргана.
7. Бүгд Найрамдах Казахстан Улсад хуримтлалын тэтгэвэр тогтоолгох өргөдлийг Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжид заасан шаардлагатай баримт бичгийг хавсарган аль нэг Талын эрх бүхий байгууллагад гаргана.



Нэг Талын эрх бүхий байгууллагад тэтгэвэр тогтоолгох зорилгоор өргөдөл гаргасан өдрийг нөгөө Талын эрх бүхий байгууллагад тухайн өдөр өргөдөл гаргасантай адилтган үзнэ.

Монгол Улсын эрх бүхий байгууллагад өргөдөл гаргасан тохиолдолд эрх бүхий байгууллага нь уг өргөдлийн эх хувь болон Монгол Улсын эрх бүхий байгууллагаар баталгаажуулж хавсаргасан баримт бичгийн хуулбарыг Бүгд Найрамдах Казахстан Улсын эрх бүхий байгууллагад өргөдөл хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор илгээнэ. Өргөдлийн маягтыг Бүгд Найрамдах Казахстан улсын эрх бүхий байгууллага батална.

Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд Талуудын эрх бүхий байгууллагын хооронд баримт бичгийг илгээх хугацааг өргөдөл хянан үзэх болон тэтгэвэр тогтоох тухай шийдвэр гаргах хугацаанд оруулахгүй.

Бүгд Найрамдах Казахстан Улсын эрх бүхий байгууллага нь өргөдлийг Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжид заасан хугацаанд авч үзнэ.

**Дөрөвдүгээр зүйл**  
**Ажилласан (даатгуулсан) хугацааг нэгтгэн тооцох**

1. Монгол Улсын өндөр насын тэтгэвэр, Бүгд Найрамдах Казахстан Улсын өндөр насын тэтгэврийн төлбөрийг тогтоохдоо нэг Талын эрх бүхий байгууллага нь нөгөө Талын улсын нутаг дэвсгэрт 1998 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл ажилласан (даатгуулсан) цаг хугацааны хувьд давхцаагүй хугацааг нэгтгэн тооцно.

2. Аль нэг Талын нутаг дэвсгэрт ажилласан (даатгуулсан) хугацааг ажилласан (даатгуулсан) тухайн Талын эрх бүхий байгууллагаас энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйлд заасан журмын дагуу баталгаажуулсан нөхцөлд тооцно.

3. Талуудын улсын нутаг дэвсгэрт цэргийн алба хаасан болон их ба (эсхүл) дээд сургуулийн дараах болон тусгай мэргэжлийн дунд боловсролын тогтолцооны сургуульд суралцсан, түүнчлэн оюун санааны (шашны) боловсролын байгууллагуудад суралцсан хугацааг тэтгэвэр тогтоосон Талын улсын хууль тогтоомжийн дагуу ажилласан (даатгуулсан) хугацаанд тооцно.

**Тавдугаар зүйл**  
**Тэтгэврийг шилжүүлэх**

1. Тэтгэвэр авагч Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад байнга оршин суухаар гарсан тохиолдолд хуимтлалын тэтгэврийг шилжүүлнэ.

Бүртгэлийн дугаар	80-4
МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ	
ХАРДААНЫ ИМНЭЛ	
Түүлээж сэргэсэн ажилтны гарынгүсэг	
2025 04 14	
2025 оны ... сарын ...-ныг эхэр -	

2. Хуримтлалын тэтгэврийг гүйлгээ хийсэн өдрийн Бүгд Найрамдах Казахстан Улсын валютын албан ханшаар Монгол Улсын үндэсний валютад хөрвүүлж, тэтгэвэр авагчийн дансанд шилжүүлнэ.

**Зургадугаар зүйл**  
**Талуудын хамтын ажиллагаа**

1. Талуудын бүрэн эрхт байгууллагууд нь энэхүү Хэлэлцээрийн хамрах хүрээнд хамаарах хууль тогтоомжид орсон аливаа өөрчлөлт, түүнчлэн бүрэн эрхт байгууллага, эрх бүхий байгууллагуудын өөрчлөлтийн талаар харилцан мэдээлж байна.

2. Талуудын бүрэн эрхт болон эрх бүхий байгууллагуудын төлөөлөгчид нь энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэх зорилгоор хоёр Талд эзлжлэн уулзалт зохион байгуулах эрхтэй.

3. Нөгөө Талын улсын нутаг дэвсгэрт ажилласан (даатгуулсан) хугацааг баталгаажуулах зорилгоор, түүнчлэн тэтгэвэр тогтоох, олгох, зогсоо болон энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад асуудлаар нэмэлт мэдээлэл, баримт бичиг авах шаардлагатай тохиолдолд нэг Талын эрх бүхий байгууллага нь нөгөө Талын эрх бүхий байгууллагад хүсэлт гаргана.

Эрх бүхий байгууллага хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 30 өдрийн дотор хариуг илгээнэ. Заасан хугацаанд хариу илгээх боломжгүй тохиолдолд эрх бүхий байгууллага нь хүсэлт гаргасан эрх бүхий байгууллагад энэ тухайгаа мэдэгдэнэ.

Талуудын эрх бүхий байгууллага нь хүсэлтийн болон хүсэлтэд хариу өгөх нэгдсэн маягтыг батална.

4. Тэтгэврийн хэмжээг өөрчлөх, тэтгэврийг түдгэлзүүлэх буюу тэтгэвэр олголтыг зогсоох нөхцөл байдал үүссэн, мөн хүний хувийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд Талуудын эрх бүхий байгууллагууд холбогдох мэдээлэл авснаас хойш ажлын 5 өдрийн дотор харилцан мэдэгдэх үүрэг хүлээнэ.

**Долдугаар зүйл**  
**Хүний хувийн мэдээлэл**

1. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Талуудын хооронд хүний хувийн мэдээллийг дамжуулна. Уг мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарах бөгөөд тухайн мэдээллийг зөвхөн энэхүү Хэлэлцээр болон хүний хувийн мэдээлэлтэй холбоотой Талуудын улсын хууль тогтоомжийн хүрээнд ашиглана.

2. Талуудын бүрэн эрхт байгууллага, эрх бүхий байгууллага нь хүний хувийн мэдээллийг Талуудын улсын хууль тогтоомжийн дагуу цуглувалж, боловсруулж, хадгалж, хамгаална.

Зургадугаар дугаар ..... 20-5

МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбарыг сэргээж ажилтны гарын үсэг  
*Дж*

2009 онд ... сарын ...-ний өдөр

Наймдугаар зүйл  
Төгсгөлийн заалтууд

1. Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах ба хэрэглэхтэй холбоотой маргааныг Талууд зөвлөлдөх, хэлэлцэх замаар шийдвэрлэнэ.

2. Энэхүү Хэлэлцээрийг соёрхон батлах ба соёрхон баталсан тухайгаа Талуудын дипломат шугамаар бичгээр гаргасан хамгийн сүүлчийн мэдэгдлийг хулээн авсан өдрийн дараагийн 2 дахь сарын эхний өдөр энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр тусгай тэмдэглэл үйлдэх замаар энэхүү Хэлэлцээрт нэмэлт, веерчлэлт оруулж болох ба эдгээр нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.

4. Энэхүү Хэлэлцээрийг тодорхойгүй хугацаанд байгуулна.

Тал тус бүр нь энэхүү Хэлэлцээрийг дараагийн хуанлийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн цуцлах эрхтэй бөгөөд энэ тухайгаа тухайн хуанлийн жил дуусахаас 6-аас доошгүй сарын өмнө негөө Талд дипломат шугамаар бичгээр мэдэгдэнэ.

5. Энэхүү Хэлэлцээр дуусгавар болсон тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтуудын дагуу үүссэн эрх нь хүчинтэй хэвээр байна.

Энэхүү Хэлэлцээрийг ~~Чухалдлагад 2024 оны 10~~ дүгээр сарын ~~19~~-ны өдөр Монгол, казах болон орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд бүх эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Энэхүү Хэлэлцээрийн бичвэрүүдийн хооронд зөрүү гарах тохиолдолд Хэлэлцээрийн орос хэлээрх эх бичвэрийг хэрэглэнэ.

МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН  
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ

